

ОЛОН НИЙТИЙН БИЧИЛ ТӨСЛИЙН УРАЛДААН ЗАРЛАГДЛАА

"Монголын андууд" ТББ-ын олон нийтийн бичил төслийг дэмжих санаачилга нь Монгол, АНУ хоёр орны боловсрол, соёлын солилцоо, нийгмийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, олон нийтэд түшиглэсэн жижиг төслүүдийг санхүүжүүлдэг. Энэхүү үйл ажиллагаагаараа бид цаашид үргэлжлэн хэрэгжих боломжтой зөв үндэслэл бүхий төслийг бага хэмжээний санхүүжилтээр (500\$-1000\$) дэмждэг ба энэ удаад хөдөө орон нутгийн өсвөр үеийнхэн, залуучуудад чиглэсэн эсвэл өсвөр үеийнхэн, залуучуудаар ахлуулан санаачилсан бичил төслүүдийг дэмжинэ. Монгол залуусын оюун санаа, эрч хүч, 21-р зуунд улс орныхоо нийгэмд авчрах шинэлэг санал санаачилга, шинэ харах өнцгүүд чухал гэдгийг мэдэхийн хувьд бид тэднийг аль болох боломжоор хангаж, дэмжихийг хүсэж байгаа юм.

Олон нийтийн төслүүдийг олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны томоохон байгууллагууд тэр бүр санхүүжүүлдэггүй бөгөөд олон нийтэд түшиглэсэн төсөл, хөтөлбөрүүд тавьсан зорилгоо бодит болгох санхүүжилт олоход бэрхшээлтэй байдаг. "Монголын андууд" ТББ-ын энэхүү хөтөлбөр нь тус асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Энэхүү хөтөлбөрийг Энх тайвны корпусын сайн дурын ажилтнуудын нийгэмдээ туслах зорилгоор хэрэгжүүлдэг байсан Бичил төслийн тусламжийн хөтөлбөрөөс санаа авч эхлүүлсэн. "Монголын андууд" ТББ-ын энэхүү хөтөлбөр нь 2006 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн төслийг, 2007 онд Говийн радио төслийг санхүүжүүлснээр анхлан эхэлж байсан бөгөөд өмнө нь олгогдож байсан бүх санхүүжилт олон нийтийн санаачилга дээр тулгуурласан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Бичил төслийн саналыг **2023 оны 4-р сарын 18-ны** өдрийг хүртэл хүлээн авах бөгөөд ирсэн санал бүрийг "Монголын андууд"-ын гишүүдээс бүрдсэн комисс тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу шүүнэ. Санхүүжилт олгох тухай эцсийн шийдвэрийг комиссын санал, санхүүжилтийн боломжит нөхцөлд үндэслэн гаргана. Төсөл нь олон нийтээс дэмжлэгтэй байхаа батлан харуулах шаардлагатай ба үүний тулд төслийн нийт төсвийн 25%-иас доошгүй хувийг төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс шууд болон шууд бусаар гаргах ёстой. Төслийн санхүүжилтийн хэмжээнд хязгаар тавихгүй боловч аль болох олон төслийг дэмжих үүднээс 500 орчим ам.долларын санхүүжилт олгож байсан удаатай гэдгийг анхаарна уу.

Англи, монгол хэлний аль нэгийг сонгон материалаа ирүүлэх боломжтой ч шалгаруулах комиссын зарим гишүүн АНУ-д байдгийг харгалзан англи хэл дээр ирүүлэхийг санал болгож байна.

Хэрэгтэй линкүүд: <http://friendsofmongolia.org/what-we-do/grants/>

Нэмэлт мэдээлэл авах бол: grants@friendsofmongolia.org

CALL FOR PROPOSALS!

"The Friends of Mongolia Community Development Grant program provides financing for small community-based projects in Mongolia that further education, cultural exchange, and community development between both countries. These grants provide a small amount of funding (500\$-1000\$) that can go a long way for the right cause. This season's theme focuses on promoting youth designed/youth led projects in the countryside. We recognize the spirit and energy the Mongolian youth possess, the innovative and fresh perspectives that they bring to bear on the 21st Century society of Mongolia, and we want to enable and empower them as much as possible.

Community projects generally do not attract funding from large multilateral or bi-lateral donors, and modest community-based programs struggle to find appropriate funding to support their program goals. The FOM Community Development Grant program is intended to address these issues.

This program was inspired by the Small Project Assistance (SPA) grant program that has been used by many Peace Corps Volunteers to help their communities. The Friends of Mongolia grant program began in 2006 with a grant to the National Center Against Violence and a 2007 grant to the Gobi Radio Project. All FOM Community Development Grants are community initiated and implemented.

Proposals will be accepted until **April 18th, 2023** and each proposal is reviewed by a committee made up of Friends of Mongolia Members using a standard scoring method. Final funding approval for proposals is made based on the Review Committee recommendations and the availability of funds. Each proposal should demonstrate community-based support for a project through a minimum of 25% local in-kind contribution of labor and materials to the overall budget of the project. While there is no limit for how much an application can request, historically Friends of Mongolia has awarded grants of \$500 to approve as many proposals as possible.

While we try to accommodate both languages, we encourage applications in English as some of the reviewing panel is based in the USA.

Helpful links: <http://friendsofmongolia.org/what-we-do/grants/>

For further information: grants@friendsofmongolia.org